

“Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 03-р сарын 11-ний өдрийн
03/2023. тоот тогтоолын хавсралт

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү баримт бичиг нь компанийн хэмжээнд байрмтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/, Гүйцэтгэх удирдлагын багийн болон компанийн нийт ажилтан ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтоож, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.
- 1.2 Цалин урамшууллын бодлогыг Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Түмэн шувуут” ХК компанийн дүрэм, Компаний засаглалын кодексе болон бусад холбогдох хууль тогтоомж эрх зүйн баримт бичигт нийцүүлэн гаргана.

ХОЁР. ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1 Цалин, урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1 ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох
 - 2.1.2 цалин, урамшууллыг шударга хуваарилах, хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх
 - 2.1.3 цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох
 - 2.1.4 хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах
- 2.2 ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын хороо /цаашид “Хороо” гэх/ нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно. Үүнд:
 - 2.2.1 тогтмол цалин
 - 2.2.2 компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин
 - 2.2.3 мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал
 - 2.2.4 компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшуулал.
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.
- 2.4 Хороо нь компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 2.5 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

ГУРАВ. ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- 3.1 ТУЗ-ийн гишүүн нь тогтмол үндсэн цалин хөлстэй байна. Энэхүү цалин хөлс нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвараа дайчлан ажиллах, гишүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэсэн байна.
- 3.2 ТУЗ-ийн гишүүнд үндсэн цалин хөлснөөс гадна дараах хэлбэрийн нэмэгдэл цалин хөлс, урамшууллыг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр олгож болно. Үүнд:
 - 3.2.1 Хуралд оролцсон тохиолдол бүрд
 - 3.2.2 Хороодын удирдах цалин
 - 3.2.3 Хараат бус гишүүний нэмэгдэл цалин
 - 3.2.4 Хорооны үйл ажиллагаанд оролцсон тохиолдол бүрд
- 3.3 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг Төлөөлөн Удирдах Зөвлөл тогтооно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- 4.1 Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн цалин хөлсний бүрдэл нь үндсэн цалин болон урамшууллаас бүрдсэн байна.
- 4.2 Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох системийг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо боловсруулж, батлан мөрдөнө.
- 4.3 Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч, урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох шийдвэрийг ТУЗ энэхүү бодлогод нийцүүлэн гаргана.

ТАВ. КОМПАНИЙН АЖИЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- 5.1 Энэхүү бодлого зарчимд нийцүүлж компаний нийт ажилчдын цалин, урамшууллыг ТУЗ тогтооно.
- 5.2 Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд энэхүү бодлого, зарчимд нийцүүлэн компаний ажиллагсдад гүйцэтгэх удирдлагаас цалин, урамшууллыг олгож байна.

ЗУРГАА. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ

- 6.1 Энэхүү бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр өөрчилж, сайжруулж, хүчингүйд тооцож болно.
- 6.2 Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо хяналт тавьж ажиллана.